

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Аймгийн Онцгой комиссын хүрээнд: Улсын Онцгой комиссын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны хуралдаанаар баталсан Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын ажиллах журам, Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай хууль тогтоомжууд, Улсын Онцгой комиссын хурлын тэмдэглэл, албан даалгавар болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аймгийн Онцгой комиссоос 2021 оны 06 дугаар сард дараах ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн Онцгой комисс тайлант 6 дугаар сард 24 удаа, Онцгой комиссын дэргэдэх шуурхай штаб 12 удаа хуралдаж аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 752 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 21 тогтоол, аймгийн Засаг даргын 12 захирамж, Онцгой комиссын даргын 21 тушаал, 2 албан даалгавар, АОК-ын дэргэдэх шуурхай штабын 2 шийдвэр, 36 тогтоол үүрэг хүргүүлэх болон холбогдох албан бичиг, баримтыг гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Ховд аймагт анхны тохиолдол батлагдсан 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрөөс хойш 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт батлагдсан тохиолдол 550 болоод байна.

Энэ хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасаг болон шинэ Хүүхдийн 50 ортой эмнэлэгт тусгаарлан эмчилж нийт 347 иргэн эмчлэгдэн эдгэрч гарсан.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд аймгийн Онцгой комиссын шийдвэрээр хүнсний хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлж аймгийн аюулгүй нөөцөд бүрдүүлсэн нөөцийн махыг Жаргалант сумын 11-н хүнсний дэлгүүрээр иргэдэд үхрийн мах 18 тн, хонины мах 15 тн, ямааны мах 2 тн, нийт 35 тн махыг худалдан борлууллаа.

Аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабын жижүүр аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 34 дүгээр тушаалаар Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Бүсийн

оношилгоо эмчилгээний төв, Зоонозын өвчин судлалын төв, Мэргэжлийн хяналтын газраас тус тус нэг алба хаагч 24 цагийн хугацаатай үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед Бүсийн Оношилгоо, эмчилгээний төвийн бэлэн байдлыг хангах зорилгоор (КОВИД-19)-ийн халдвартай өвчтөнд 271 ор, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 34 ор дэлгэн ажиллуулахаар төлөвлөн эмнэлгийн урсгал, байршлыг шинээр зохион байгууллаа.

Шуурхай хариу арга хэмжээний багт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааг гарган гарын үсэг зуруулж баталгаажуулсан. Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмч, эрүүл мэндийн ажилтны судалгааг цахимаар Эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн мэдээнд өдөр бүр хамруулж байна. Коронавирусын /COVID-19/ халдварын үед ажиллах эмч эмнэлгийн мэргэжилтний судалгааг 25 эрүүл мэндийн байгууллагаас авч нэгтгээд байна.

Аймгийн МХГ, ОБГ, ЦГ, Иргэдийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилчдын бүрэлдэхүүнтэй нийт 7 ажлын хэсэг УОК-ын даргын 41 дүгээр тушаалаар баталсан 14 үйл ажиллагааны чиглэлээр аймагт ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгууллаа.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан Худалдааны бөөний төв, зах -9, Үсчин 32, Барааны худалдаа 28, Халуун ус 5, Жолооны курс 5, Хоол үйлдвэрлэл 32, Банк бус санхүүгийн байгууллага 2, Зочид буудал 2, Сургалтын төв 2, Автозасвар 8, Авто угаалга 5, Ахуйн үйлчилгээний салбар 18, Бялдаржуулах төв 2, нийт 150 байгууллагын үйл ажиллагааг эхлүүлээд байна.

ХӨСҮТ-өөс 8 удаагийн татан авалтаар БНХАУ-ын “Синофарм” үйлдвэрийн “Вероцелл” вакциныг 85899 хүн тун, Файзер вакцин 3192 хүн тун, астрозенека вакцин 10 хүн тун вакциныг тус тус татан авч дархлаажуулалтын хүйтэн хэлхээний горим, вакцины хаяг шошгололт, нэр, хэлбэр, тун хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр зэргийг тулган зургаар баталгаажуулж хяналт тавин ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Ховд аймгийн хэмжээнд 1-р тунг 45501 иргэн, 2-р тунг 38146 , нийт 83647 иргэнийг хамруулаад байна.

Захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаа худалдан борлуулдаг 274 аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажилласан.

Хяналт, шалгалтын хүрээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаатай холбоотой 1 зөрчил илрүүлж, 1 хуулийн этгээдийг Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу нийт 500.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль болохтой холбогдуулан аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабын 2021 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар 91 сонгуулийн хэсгийн хорооны санал авах байранд Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн байгууллага, Нутгийн захиргааны байгууллагаас алба хаагчдыг Онцгой комиссын даргын 2021 оны 44 дүгээр тушаалаар томилгоожуулан ажиллалаа.

Ховд аймгийн санал авах 91 хэсгийн хороонд 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 06.00 - 21.00 цагийн хооронд Онцгой байдлын газраас 41, Эрүүл мэндийн байгууллагаас 97, Нутгийн захиргааны байгууллагаас 148 алба хаагч, нийт 286 алба хаагч үүрэг гүйцэтгэлээ.

Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж аймгийн сонгуулийн хэсгийн хороодын дарга нарт Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам” -ын хэрэгжилтийг хангаж ажиллах 2 цагийн сургалтыг зохион байгуулан ажилласан.

Долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаригуудад аймгийн хэмжээнд цаг үеийн нөхцөл байдлын талаар болон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээ мэдээллийг орон нутгийн “Олон ястан” телевизийн мэдээллийн цагаар шууд дамжуулж иргэд, олон нийтэд нэвтрүүллээ.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах сэрэмжлүүлэг мэдээг орон нутгийн www.khovdtimes.mn, www.khovdnews.mn, www.newkhovd.mn, www.khoa.nema.gov.mn, www.khovd.boet.gov.mn сайтууд, Ховд, Олон ястан, Жаргалант, ЭКО телевиз, Ховдын мэдээ, Ховдын толь зэрэг хэвлэл мэдээллийн сувгууд, чанга яригчаар өдөр бүр 3 удаагийн давтамжтайгаар нийт 748 удаа нэвтрүүлж иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг хурдан шуурхай хүргэж ажиллаж байна.

Ховд аймгийн хэмжээнд нийт 33 хяналтын цэг, 52 автомашин 196 алба хаагч нэг ээлжинд үүрэг гүйцэтгэж байна.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс аймгийн Онцгой комисст хандив ирүүлсээр байна.

Хоёр: Нутгийн удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 22 өргөдөл бичгээр хүлээн авч, 12 өргөдлийг шийдвэрлэж, 10 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 6 өргөдөл бичгээр хүлээн авч, 5 өргөдлийг шийдвэрлэж ажиллав.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 1 сувгаар 17 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 17 ирүүлснээс гомдол 5, санал хүсэлт 11, шүүмжлэл 1 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 9 иргэний санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 53.0 хувьтай байна. Үүнд хууль эрх зүй 1, орчны эрүүл ахуйн асуудлаар 4, Эрүүл мэндийн асуудлаар 5, бусад асуудлаар 7 иргэн тус тус хандаж, шийдвэрлэлт 1-10 хоногтой 9, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа гомдол 8 байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл, санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй болно.

Аймгийн Нутгийн удирдлагын ордонд үйл ажиллагаа явуулж байсан “Нэг цонхны үйлчилгээний төв”-ийг 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс аймгийн Засаг даргын захирамжаар “Үйлчилгээний нэгдсэн төв” болгон өөрчлөн зохион байгуулалт хийж, Жаргалант сумын Нутгийн удирдлагын ордонд ажиллуулахаар сумын Засаг даргад үүрэг чиглэл хүргүүлэн хэвийн ажиллаж байна.

Гурав: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 6 дугаар сард улсын төсвийн санхүүжилтээр 31097.3 сая төгрөг ирэхээс бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 4235.2 сая төгрөгийн санхүүжилтээс 4044.1 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 6330.6 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 3826.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 15621.8 сая төгрөг, цэцэрлэг 7260.4 сая төгрөг, хүн эмнэлэг 3530.4 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 229.9 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 246.9 сая төгрөг тус тус олголоо.

Төсвийн, орон нутгийн өмчийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, төсөл, сангуудын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцлийг хүлээн авсан дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх илтгэлийг аймгийн ИТХ-д хүргүүлж, Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн цаашид авах арга хэмжээний талаар үүрэг чиглэл өглөө.

Засгийн газрын тогтоол шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-ын тогтоолын биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гарган нэгтгэж холбогдох хэлтсүүдэд хүргүүлж ажиллалаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “SMS” МТ үйлчилгээгээр төсвийн захирагч, нягтлан бодогчдод мессеж хүргүүлэн урьдчилан сануулж төсөв, санхүүгийн мэдээллийг хугацаанд нь бүрэн ил тод мэдээлж байна. Тайлант 6 дугаар сарын байдлаар Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 6636 ширхэг зардлын ваучер бичиж, 47640,0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг гүйцэтгэлээ.

Сангийн яамнаас Эрхийн бүртгэлийн сан системд хийгдсэн хөгжүүлэлт, мэдээллийн бааз бүрдүүлэлт системд гарч буй асуудал тэдгээрийг хэрхэн шийдэх, ашиглах талаар хийсэн сургалтанд аймаг сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжууллаа.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сан, Засаг дарга, Хөрөнгө оруулалт, Барьцаа дансны санхүүгийн 2019, 2020 онуудын баримтуудад аудитын шалгалт хийгдэж байна.

Манхан баян таван хайрхан хадгаламж зээлийн хоршоо, Ачит алтан хундага, Ховд зочид буудал ХХК-дын санхүүгийн тайланг албан бичгээр хүлээн авч хуулийн дагуу өөрчлөлт оруулан засаж баталгаажууллаа.

Сумдын Засаг дарга болон албан байгууллагын дарга эрхлэгч нарт 2021 оны 5/939 тоот албан бичиг хүргүүлж, Сангийн яамны шагналын тодорхойлолтуудыг

хүлээн авч, хэлтсийн хурлаар хэлэлцүүлэн сум, байгууллагуудаас шалгарсан шилдэг тэргүүний 15 санхүүчдыг шагнуулахаар баримт бичгийг Сангийн яаманд хүргүүллээ.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь төсвийн Ерөнхийлөн захирагчаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан “Шим ус” ОНӨААТҮГазар, Орон нутгий өмчийн газар, Сангийн яамны удирдамжийн дагуу Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар зэрэг төсөвт байгууллагуудын 2018, 2019, 2020 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт хийж байна.

Аймгийн Татварын хэлтэс нь эхний хагас жилийн НӨАТын тайланг 98.9 хувь хүлээн авлаа. 2021 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар улс, аймаг, сум орон нутгийн төсөвт 8557,1 сая төгрөг оруулахаас 9811,7 сая төгрөг орсон нь 114,7 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 2108,5 сая төгрөг оруулахаас 3076,6 сая төгрөг оруулсан нь 145,9 хувийн, аймгийн төсөвт 5351,2 сая төгрөг оруулахаас 5407,1 сая төгрөг оруулсан нь 101 хувийн, сум орон нутгийн төсөвт 1097,4 сая төгрөг оруулахаас 1292,6 сая төгрөг оруулсан нь 117,8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн улсын бүртгэл, статистикийн газартай тулгалт хийж Тахаст болон Tips програмд бүртгэж, ХХК 66, Нөхөрлөл 16, төрийн бус байгууллага 11, салбар 1, хоршоо 3 нийт 96 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдлээ.

Хяналт шалгалтанд 13 татвар төлөгчийг хамруулж, татвар төлөгчийн гаалийн болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгаснаар шалгалтын явцад 1456,0 сая төгрөгийн зөрчилд 139,2 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 57,2 сая төгрөгийн торгууль, 4,1 сая төгрөгийн алданги тооцож, нийт 200,6 сая төгрөгийн нөхөн татвар торгууль, алданги ногдууллаа.

Дөрөв: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:

Тав: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Аймгийн боловсрол, соёл урлагийн газар нь 2021 оны 6 дугаар сард Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 4 чиглэлийн дагуу 30 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь гүйцэтгэлээ.

“Суурь боловсролын сургалтын чанарыг сайжруулахад мэдээлэл харилцааны технологийг оновчтой ашиглах нь” төслийн хүрээнд зохион байгуулж буй баруун бүсийн онлайн сургалтыг 6 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд Ховд, Увс, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн боловсрол, соёл, урлагийн газраас 4, суурь боловсролын сургалт хариуцсан 20 мэргэжилтэн, сумдын сургуулийн сургалтын менежер, суурь боловсролын багш 50, багийн ахлагч 6 болон төслийн загвар аймаг Баянхонгор, Сэлэнгэ, Хэнтий аймаг, Сонгинохайрхан дүүргийн төлөөлөл 8, төслийн зөвлөх профессорын баг 6, төслийн нэгж 2 нийт 93 хүн оролцуулан зохион байгууллаа. Сургалтын зорилго орон нутгийн төслийн багаас боловсруулсан сургалтын 6 цахим хэрэглэгдэхүүний эхний хувилбартай танилцаж, цаашид сайжруулан эцэслэн боловсруулах талаар зөвлөмж өгөх, төслийн үр дүнг аймгийн нийт сургуульд түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн болно.

"Эрх тэгш элсэлт" аяны хүрээнд 2021-2022 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэн суралцах хүүхэдтэй эцэг эхийн цахим сургалтыг 6 дугаар сарын 4-нд зохион байгууллаа. Сургалтаар 32 эцэг эхэд зөвлөгөө өглөө.

Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудалд 1000 багшийн арга зүйн сургалтыг ХБҮЗ, БШУЯам, НБГ, ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн, МУИС, МУБИС, Хүмүүн бичиг сонин, 21 аймгийн салбар зөвлөл хамтран МХУЗ-ын 30 багшид зохион байгууллаа.

Хүүхдийн эх хэлний боловсролд ЭШ-ний хурал /ХБҮЗ, НБГ, ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн, Монгол хэл бичгийн багш, судлаачдын үндэсний холбоо, 21 аймгийн салбар зөвлөл/-д СӨБ, бага ангийн 20 багшийг оролцууллаа.

МУБИС-ийн багш Д.Соронзонтой хамтран “Монгол бичгийн үгийн бүтэц, дүрэм” сургалтыг МХУЗ-ын 54 багшид цахимаар явууллаа.

БШУЯамнаас зохион байгуулсан сургууль цэцэрлэгийн эмч, нярав тогооч нарын сургалт 06 дугаар сарын 07-11-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тус сургалтад цэцэрлэгийн 112, сургуулийн 97 боловсролын 3 мэргэжилтэн нийт 212 хүн хамрагдсан. Сургалтаар сургуулийн хоол үйлдвэр үйлчилгээний хуулийн тухай мэдээлэл, хүүхдийн хооллолт илч норм, хадгалалт, тээвэрлэлт хоол хийх арга аргачлалын талаар онол дадлага ойлголт чадвар олголоо.

Олон Улсын Стандартын Академиас Байгаль Орчны Мэдээлэл, Сургалтын төв ТББ-тай хамтран "Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015

стандартын дотоод аудитор" бэлтгэх сургалтад ТХБ-төслийн орон нутгийн техникийн зөвлөн зохицуулах багийн 3 гишүүн цахимаар хамрагдлаа. Сургалтаар дотоод аудитор хийх арга зүйд суралцаж байна.

Портеж хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалтад 6 дугаар сарын 2-12-ны өдрүүдэд бага боловсрол хариуцсан мэргэжилтэн хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй ур чадвараа сайжрууллаа.

ТХБ-2 төслөөс зохион байгуулсан СБААХ-арга зүйн сургалтад Буянт, Мөнххайрхан, Жаргалант 1, 2 дугаар сургуулийн нийт 36 багш 4 мэргэжилтэн хамрагдлаа.

Японы хүүхдийг ивээх сангийн хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих орон нутгийн зөвлөлийн уулзалтад бага боловсрол хариуцсан мэргэжилтэн 6 дугаар сарын 18-нд хамрагдлаа. Орон нутгийн зөвлөлийн гишүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудал, ололт амжилт, тулгарч буй бэрхшээл шийдвэрлэх арга замын талаар мэдээлэл хийлээ.

“Чанартай боловсрол-Шинэ Ховдын ирээдүй” аяны хүрээнд элсэлтийн ерөнхий шалгалтад зөвлөх үйлчилгээг 6 дугаар сарын 24-ний байдлаар 10 судлагдахуунаар онлайн хичээл 137, танхимын давтлага 751 багш сурагчдад 62 удаа, энэ хугацаанд 69 сорил авч 675 материалыг сурагчдад дэмжлэг өгөх зорилгоор байршуулсан байна.

Хүснэгтээр харуулбал :

д/д	Судлагдхуун	Зөвлөх багшийн хичээл	Тухайн сургуулийн сурагч, багш нарт цахимаар болон танхимаар өгсөн зөвлөмж		Цахим группэд байршуулсан хичээл, зөвлөмж	Авсан сорил
		тоо	тоо	хамрагдсан сурагч багшийн тоо	тоо	тоо
1	Монгол хэл	12	7	36	339	9
2	Математик	11	7	56	29	8
3	НТМ	13	4	60	28	12
4	Монголын түүх	10	1	6	4	5
5	Газарзүй	17	2	4	19	12

6	Хими	19	7	129	81	3
7	Биологи	17	7	80	92	2
8	Физик	14	11	200	48	4
9	Англи хэл	12	8	170	23	7
10	Орос хэл	12	8	10	12	7
	10 хичээл	137	62	751	675	69

Боловсрол, Шинжлэх ухааны яамнаас зохион байгуулж буй “Цахим төсвийн төсөл 2022” үйл ажиллагааг сургууль, цэцэрлэгүүдэд сургалт мэдээлэл хүргэн шинэ системийн сургагчаар ажиллаж байна.

Сургууль, цэцэрлэгийн гамшиг эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх албан бичиг хүргүүлсний дагуу үнэлгээ хийх явцад сургууль цэцэрлэгийн үнэлгээний багт тулгамдаж буй асуудлаар цахим уулзалт хийлээ. Цахим уулзалтад ББТОБГ-ын мэргэжилтэн дэслэгч н.Цогзаяа арга зүйн зөвлөгөө болон үнэлгээ хийж ирүүлсэн сургууль, цэцэрлэгийн тайланд хийсэн дүн шинжилгээг танилцууллаа.

Дотуур байрны багш нарын цахим уулзалтыг 5 багаар зохион байгууллаа. Тус уулзалт нь Ковид 19 цар тахлын нөхцөл байдалд хэрхэн хамтран ажилласан бүтээлч ажлын тайлан танилцуулагдлаа. Шилдэг туршлагаар Эрдэнэбүрэн сумын “Хүн бүр нэг дэр” цар тахлын үеийн ажилтны хувцасны халдвар хамгаалал, Алтай сумын “Ажилтан бүр нэг бүтээлэг” ажлууд сайн туршлагаар нэрлэгдлээ.

Төрийн өмчийн 33 цэцэрлэгийн эрхлэгчдийн 2021 оны эхний хагас жилийн ажлын тайланг уншиж танилцан үнэлгээ хийлээ. Цэцэрлэгийн өөрийн үнэлгээг журмын дагуу үнэлэхэд аймгийн дундаж 83% тай байна.

2021 оны 6 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр хийсэн ажлын тоон үзүүлэлтийг нэгдсэн жагсаалтаар гаргаж, нэгтгэв. Үүнд 33 цэцэрлэгийн эрхлэгч багш нар 359 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт 98 хувийн ирцтэй, 293 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 258 үүрэг даалгаврыг хугацаандаа буюу 88 хувийн биелэлттэй, 1363 онлайн гарын авлага хүүхдэд хүргэж ажиллалаа.

СӨБ-ын төсөлт үйл ажиллагаа сургалтад хамрагдсан 268 бүлгийн багш нарт гарын авлага авч, хүргүүллээ

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг гарган агуулгын хоцрогдлын судалгааг сургууль, судлагдахуун бүрээр гаргалаа.

Боловсролын чанарын шинэчлэл төслөөс ирсэн I-Ү ангийн STEM сургалтын 30580 ширхэг, 38161087,80 төгрөгийн хэрэглэгдэхүүн орлогод авлаа.

Боловсролын удирдлагын мэдээллийн системд ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсрол төвд суралцаж байсан бүх төгсөх ангийн сурагчдыг төгсөлтийг хийлгэж төгсөлтөөс элсэлт хийхэд бэлэн болгов. Мөн дэвших сурагчдыг анги дэвшүүлэх үйлдлийг хийлгүүлж 2021 оны хаалт хийлгэж, 2021-2022 оны хичээлийн жилийн нээлтийг хийхэд бэлэн болголоо. Нийт ерөнхий боловсролын сургуулийн багш нарын цахим журналын хаалтыг хийлгүүлж, сургалтын менежерүүдэд цахимаар архивлах чиглэлийг өгч ажиллав.

Аймгийн музей, 16 соёлын төвүүдэд "Эх нутаг, өв соёлоо эрхэмлэн дээдэлье" Монгол түмний аяны хүрээнд зохион байгуулж байгаа уралдааны удирдамжийг дахин хүргүүлж үйл ажиллагааг эрчимжүүллээ.

2020-2021 оны хичээлийн жилийн "Иргэн" төслийн цахим шалгаруулалтад Ховд аймгийн 4 сургуулийн 5 багийн 108 сурагч 4 багш оролцож Ховд сумын Х.Жайналхан багштай "Тэмүүлэл" багш шилдэг цомогтой багаар шалгарч Жаргалант сумын 6 дугаар сургуулийн Б.Дариймаа багштай I-Gen баг үндэсний шалгаруулалтад оролцох эрх авч үндэсний шалгаруулалтад амжилттай оролцлоо. Оролцсон багш сурагч бүрд "Батламж" дурсгалын зүйл "Иргэний боловсролын төв"-өөс гардууллаа.

Ерөнхий боловсролын 25 сургууль, 2 насан туршийн боловсрол төвд суурь боловсрол, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөж байгаа суурь боловсролын өдрийн ангийн 1414, дүйцсэн хөтөлбөрийн 108, нийт 1522, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөж байгаа өдрийн ангийн 1215, дүйцсэн хөтөлбөрийн 103 нийт 1318 сурагчийн боловсролын баримт бичиг олгох ажлыг ЕБ-ын сургуультай хамтран зохион байгуулж тайлан, 136 хуудас бүхий "Б" Маягтыг БШУЯ болон БСУГ-ын архивт хүлээлгэн өглөө. Энэ хичээлийн жилд бага боловсролыг 1712 сурагч эзэмшин төгссөн.

Сургуулийн өмнөх боловсролын төгсөлтийг төрийн өмчийн 33 цэцэрлэг, хувийн өмчийн 10 цэцэрлэгүүдээр боловсролын удирдлагын мэдээллийн системд бүрэн дуусгуулж 2020-2021 оны хичээлийн жилийн хаалтыг хийж 2021-2022 оны хичээлийн жилийн систем дэх нээлт хийхэд бэлэн болгосон. Нийт 43 цэцэрлэгт 6918 хүүхэд төгсөлт дэвшилт хийснээс 4377 хүүхэд дэвшив

2020 онд "Зөвлөх" зэргийн болзол хангаж үнэмлэх авсан, 2021 оны "Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт"-д амжилттай суралцсан сургалтын байгууллагад эхний

болон 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа багш, удирдах болон бусад ажилтны мэдээллийг цахимаар БМДИ-аас хүлээн авч ЕБС, цэцэрлэгүүдэд хүргүүлэн БУМС-д тухайн ажилтны боловсрол хэсгийн мэргэжил дээшлүүлэлтэд бүртгэж оруулах чиглэл өгч ажиллалаа.

Төсвийн хуваарийн дагуу 6 дугаар сарын санхүүжилтийг сангийн яамнаас сарын хуваарьт өөрчлөлт орж хасагдаж ирсэн дүнгээр ЕБС- 4370,6 сая төгрөг, СӨБ- 1725,8 сая төгрөгийн санхүүжилтийг тухайн сард олгов.

Энэ хичээлийн жилд бага боловсрол эзэмшин дэвшин суралцсан 8528, дунд ангид суурь боловсрол эзэмшин дэвшин суралцсан 5254, ахлах ангид бүрэн дунд боловсрол эзэмшин дэвшин суралцсан 2612 суралцагч байна.

Гадаадын их дээд сургуульд суралцах Аппостид гэрчилгээ авахад шаардагдах тодорхойлолтыг 10 сурагчид олголоо.

2021-2022 оны хичээлийн жилд зорилтот бүлэгт шаардлагатай сурах бичгийн захиалгыг ерөнхий боловсролын сургуулиудаас маягтын дагуу авч нэгтгэн БШУЯ-нд хүргүүллээ. 1 дүгээр ангийн 2302, 2 дугаар ангийн 1010, 3 дугаар ангийн 777, 4 дүгээр ангийн 974, 5 дугаар ангийн 954, 6 дугаар ангийн 316, 7 дугаар ангийн 301 ширхэг номын захиалга өглөө.

БШУЯ, НҮБ-ын хамтарсан “Монгол улсад КОВИД-19 тархалтыг хязгаарлах үүнээс гарах сөрөг нөлөөллийг бууруулахад нэн шаардлагатай нийгмийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд ЮНЕСКО-гийн санхүүжилтээр хэвлүүлсэн “Цахим аялал” комик ном 52 ширхэгийг, “Сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл II” номыг Соёмбо принтинг хэвлэлийн газраас 63 ширхэгийг татан авалт хийв.

Эрүүл мэндийн чиглэлээр: Тайлант сард халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх товлолын заавал хамрагдах дархлаажуулалтыг 99.5 хувийн хамралттай зохион байгуулж мэдээг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанд хүргүүллээ.

Ковид-19 халдвараас сургуулийн 12-17 насны хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх зорилгоор АНУ, ХБНГУ-ын Pfizer-Biontech үйлдвэрийн 15792 хүн/тун бүхий Комирнэти вакциныг татан авч 2021 оны 06 дугаар сарын 28-ны байдлаар нийт 9256 хүүхэд хамрагдахаас 3613 хүүхэд буюу 39.03 хувийн хамралттай байна.

Тайлант 6 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр Ковид-19 халдварын 761 тохиолдол бүртгэгдэж, 440 хүнийг эмчлэн эдгэрүүлж, аймгийн хэмжээнд ойрын хавьтлын 1651, тусгаарлан ажиглах байранд 16, гэрийн тусгаарлалтад 1635, гэрийн ажиглалтад 347 иргэн байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээ мэдээллүүдийг гэрээт телевиз болон сайтуудаар дамжуулан ард иргэдэд хүргэж, гепатит, сүрьеэтэй иргэдэд сургалт сурталчилгаа явуулахад хэрэглэгдэх нийт 198 ширхэг сурталчилгааны материалыг сум, өрхөд хуваарилан хүргэж, “Ковид-19 дархлаажуулалтад жирэмсэн эхчүүдийг хамруулахад анхаарах зүйлс”, “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цахим сургалтуудад холбогдох мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжууллаа.

2021 оны эхний 5 сарын байдлаар эхийн ноцтой хүндрэл 4, эхийн эндэгдэл 1 бүртгэгдэж, Булган сумын нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн эхийн эндэгдлийг комиссын хурлаар хэлэлцэн, дүгнэлт өгч, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэр гаргаж, холбогдох материалуудыг ЭМЯ-ны Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл болон ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд хүргүүлээд байна.

Цаашид эх хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний талаарх цахим уулзалтыг сар бүрийн эхний 7 хоногийн 5 дахь өдөр зохион байгуулж байхаар шийдвэрлэж, 16 сум, 6 өрхийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдэд БОЭТ-ийн чанарын менежер, Амаржих газрын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нар хамтран “Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээтэй холбоотой хууль, эрхзүйн баримтууд”, “Өртөмтгий жирэмсэн эхчүүдийн товлот үзлэг” сэдвүүдээр цахим уулзалт зохион байгуулж үүрэг чиглэл, зөвлөмж өгч ажиллалаа.

Тайлант сард 6-59 сартай хүүхдүүдийг өндөр тунт А аминдэмийн дархлаажуулалтанд хамруулж, тайлан, өндөр тунт А аминдэмийн захиалгыг нэгтгэн Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн хоол судлалын албанд хүргүүллээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд нийгмийн хамгааллын салбар комисс нь 2021 оны эхний хагас жилд нийт 9 удаа, хуралдаж /давхардсан тоогоор/ 136 хүүхдийн асуудлыг хурлаар хэлэлцэж, эрүүл мэндийн болон сэргээн засалтын үйлчилгээнд 46, боловсролын үйлчилгээнд шинээр 4 хүүхдийг, 113 хүүхдийн халамжийн мөнгөн

тэтгэмжийг сунгасан, 13 хүүхдийг шинээр хамруулсан, 37 хүүхдийн асаргааны тэтгэмжийг сунгасан 9 хүүхдийг шинээр тус тус хамрууллаа.

Эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн мэдээллийн сантай болгох зорилгоор бүртгэл мэдээллийг үүсгэж license.moh.gov.mn-ээр тусгай зөвшөөрөлтэй бүх эрүүл мэндийн байгууллагуудыг шивж оруулахаас одоогийн байдлаар 50 эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг уг сайтад шивж оруулаад байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас уламжлалт эмчилгээний зардлыг олгохтой холбоотойгоор тусламж үйлчилгээний чанар, мэргэжлийн хүний нөөцийг хангах зорилгоор судалгаа хийхэд өнөөгийн байдлаар 6 өрх, 4 сум уламжлалт анагаах ухааны их эмч, 8 сум уламжлалт анагаах ухааны сувилагчтай, 4 сум хүний нөөцөөр хангагдаагүй байгаа бөгөөд БОЭТ, сум өрхийн ЭМТ-үүдэд уламжлалт анагаах ухааны онолоор Коронавируст халдварыг оношлох, эмчлэх түр заавар хүргүүлж, уламжлалт анагаах ухааны идээ ундаа, эмээр дархлаагаа дэмжих, коронавируст халдварын үед уух тан эмчилгээний заавар зөвлөмжийн талаарх мэдээллийг цахимаар иргэдэд хүргэж ажиллалаа.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед ахмад настнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 60 ба түүнээс дээш настай ахмадуудад 5925 дархлаажуулах багц ирснийг сум, өрхөөс ирүүлсэн ахмад настны судалгааг үндэслэн 60-аас дээш настны тоогоор хувиарлан, тараан ажиллаж байна.

Тайлант оны эхний 5 сарын байдлаар төрөлт 856 мэдээлэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 57 төрөлтөөр, амьгүй төрөлт 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3 бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 1 тохиолдлоор тус тус буурч, эхийн эндэгдэл 1 бүртгэгдлээ.

Иргэдийн эрүүл мэндийн үзлэгт нийт 159525 хүнийг хамруулснаас урьдчилан сэргийлэх үзлэг 48235 буюу 30.23 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувиар өссөн нь Эрүүл мэндийн дэмжих төвийг шинээр нээж ажиллуулсантай холбоотой байна.

Ковидын халдварын энэ үед анхан шатны тусламж үйлчилгээний хэвийн байдлыг хангаж ажиллах зорилгоор 12 өрх сумын эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналт үнэлгээг хийж, зөвлөмж өгч ажиллалаа.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний тусгай зориулалтын 6 дугаар сарын шилжүүлгийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хийж, сумдын эрүүл мэндийн төвүүдэд өссөн дүнгээр нийт 2995247,3 мянган төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 535209,1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн тавьж олголоо.

Тус сарын байдлаар төсөвд байгууллагууд улсын төсвийн санхүүжилтээ бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 70.0 хувийн гүйцэтгэлтэй, эхний 5 сарын байдлаар салбарын хэмжээнд 33.3 сая төгрөгийн авлагатай, 516.8 сая төгрөгийн өглөгтэй байна.

Эрүүл мэндийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардлаар 1994.4 сая төгрөг, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан, Хөшөөт хөгжил сан, сум, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 85.2 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 97.6 сая төгрөг, хандив тусламжаар 85.0 сая төгрөг нийт 2262,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж, Манхан, Буянт, Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн яаралтай тусламжийн машин шинэчлэгдсэнээр тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, яаралтай болон алсын дуудлагыг шуурхай хүргэх боломж сайжирлаа.

Монгол улсын өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллганы MNS 5292:2017 стандартын 33 дугаар заалтын дагуу өрхийн эрүүл мэндийн төвд байх ёстой эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг боловсруулан, 6 өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтын хувийг гаргахад үзлэгийн хэсэг 54.1, оношилгооны хэсэг 56.7, эмчилгээний хэсэг 50.0, шинжилгээний хэсэг 48.9, сэргээн засах хэсэг 32.9, чийрэгжүүлэлтийн хэсэг 25.0, ариутгалын хэсэг 54.2, бусад 30.3 хувийн нийт өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хангалт дундажаар 44.0 байна.

БОЭТ,15 сумын эрүүл мэндийн төв, 6 өрхийн эрүүл мэндийн төвүүдээс цахилгааны нөөц эх үүсвэрийн судалгааг 23 байгууллагаас авч нэгтгэхэд 13 байгууллага цахилгааны эх үүсвэртэй, 10 байгууллага эх үүсвэргүй байна.

КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээ авах чиглэлээр ард иргэдийн эрүүл мэндийн сахин хамгаалах, эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай чанартай хүргэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан, салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2, Алтан гадас

одонгоор 12, хөдөлмөрийн хүндэт медалиар 9, Эрүүлийг хамгаалах тэргүүний ажилтан 4, Эрүүл мэндийн яамны Жуух бичгээр 6, Эрүүл мэндийн хөгжлийн төлөө тэмдгээр 1, нийт 34 хүнийг шагнаж алдаршууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS програмд 2021 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар ажил хайгч иргэд 1821, үүнээс 918 эмэгтэйчүүд байна. Тайлант сард нийт 61 иргэнийг шинээр бүртгэж, идэвхгүй жагсаалтанд байсан 288 иргэний мэдээллийг шинэчлэв.

Шинээр бий болсон 454 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн LMIS програмд шивлээ. Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 659 ажлын байрны захиалга авч, 563 иргэнийг ажлын байранд зуучиллаа. Үүнээс байнгын ажлын байранд 234, улирлын ажлын байранд 287, түр ажлын байранд 42 иргэн зуучлагдсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд нийт 503 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, бүлгийн сургалтыг 302 иргэнд, ганцаарчилсан зөвлөгөөг 201 иргэнд үзүүллээ.

Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдаж буй "Чанартай боловсрол- Шинэ Ховдын ирээдүй" аяны хүрээнд "Мэргэжил бүхэн сайхан" сэдвээр мэргэжил сонголтоо хийх гэж буй ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулан хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжлүүдээр контент нэвтрүүлэг бэлтгэж, нэвтрүүлэгт тогооч, сувилагч, барилгачин, мужаан, гагнуурчин зэрэг мэргэжлээр олон жил ажилласан дадлага туршлагатай, ажил мэргэжилдээ эзэн болсон хүмүүсээс яриа, тухайн ажил мэргэжлийн мэдээлэлд түшиглэн бэлдэж байгууллагын фэйсбүүк хуудас, орон нутгийн телевиз, сайтуудад байршуулан олон нийтэд сурталчилан ажиллаж байна.

Ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг 41 иргэн өгч шилжилт хөдөлгөөний мэдээг шинэчиллээ. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх вакумжуулсан сургалтанд 72 иргэнийг бүртгэж зөвлөгөө мэдээлэл өглөө.

Хөдөлмөрийн харилцаа , хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр барилгын үйл ажиллагаа эрхэлдэг 6 байгууллагын 136 ажилтанд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

“Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт 65 иргэн төсөл ирүүлснийг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шаардлага хангасан 44 иргэний төслийг дэмжиж 120.0 сая төгрөгийн санхүүжилт

олгохоор шийдвэрлэж, төсөл нь батлагдсан иргэдтэй гэрээ хийж хуваарь танилцуулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгож байна.

Ажлын байр нэмэгдүүлэх жижиг зээлийн арга хэмжээнд 3 иргэн төсөл ирүүлж Төрийн банкинд хүргүүлэн 2 иргэнд 20,0 сая төгрөгийн зээл олгов. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний урамшуулал олгохоор 4 аж ахуйн нэгжид 8 иргэнийг зуучлан гэрээ байгууллаа.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Орон нутгийн төсвөөс Нийгмийн халамжийн санд 73.000.000 төгрөг, Улсын төсвөөс Халамжийн тэтгэвэрт 2.381.635.770 төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмжид 925.000.000 төгрөг, Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид 545.000.000 төгрөг, Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжид 221.392.000, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт тусламжид 102.000.000 төгрөг, Хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид 631.128.000 төгрөг, Банкны шимтгэлийн санхүүжилт 1.800.000, Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулалд 11.424.000, нийт 4.892.379.770 төгрөгийн санхүүжилт авч халамжийн сангийн үйл ажиллагаа хэвийн байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд аймгийн хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын байдлаар 35318 хүүхдийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрууллаа. Шинэ төрсөн 908 хүүхэд бүртгүүлэв.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 1467 өрхийн 4510 том хүн, 3791 хүүхдэд 102,488,000 төгрөгийн төсөв зарцууллаа.

Ахмад настанд явуулын үйлчилгээ, өдрийн үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан "Ахмад чөлөөт эмч нар" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан байнгын асаргаа шаардлагатай 36 ахмад настанд явуулын үйлчилгээ үзүүлээ. Улаан загалмайн хороотой хамтарч байнгын асаргаанд байгаа 90 дээш настай 13 ахмад настанд гэрийн асрамж халамжийн үйлчилгээг үзүүллээ.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 3812 даатгуулагчийн 876158.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 4879 даатгуулагчийн 278176800 мянган төгрөгийн орлого, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 803 ажил олгогчийн 12154 даатгуулагчийг хамруулж нийгмийн даатгалын санд 4498388.5 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүллээ. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 9840 иргэнд 18406265.2 сая, тахир дутуугийн тэтгэвэр авагч 1654 иргэнд 2445689.3 мянган төгрөг, тэжээгчээ алдасны

тэтгэвэр авагч 693 иргэнд 1070881.0 мянган төгрөг, цэргийн алба хаасны тэтгэвэр авдаг 313 иргэнд 1063267.2 мянган төгрөг, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тахир дутуугийн тэтгэвэр авагч 39 иргэнд 69438.0 мянган төгрөгийн тэтгэвэр тус тус олгоод байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 768 даатгуулагчид 1212408056 мянган төгрөг, ХЧТА-н тэтгэмжид 341 даатгуулагчид 58928549 мянган төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид шинээр 154 хүн давхардсан тоогоор 446 даатгуулагчийн 488132.4 мянган төгрөг, 129 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 129 сая төгрөг тус тус зарцууллаа.

Эмнэлэгийн хөдөлмөр магадлах комисс нь тайлант 6 дугаар сард 5 удаа хуралдаж нийт 400 иргэний ХЧА-н асуудал хэлэлцэн шийдвэрлэж 39 иргэнд шинээр ХЧА-т тогтоож, 337 иргэний ХЧА-ыг сунгаж, 21 иргэний ХЧА-г цуцалж мэдээллийн баазад давхардсан тоогоор 3026 иргэн бүртгэлтэй байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: 2021 оны 06 сард иргэдээс 19 гомдол мэдээлэл хүлээн авч гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг 9, хүүхдийн эрсдэлийн үнэлгээг 10, гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээг 9 иргэнд хийж, 12 иргэний аюулгүй байдлыг хангаж эрүүл мэндийн болон сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж, хамтарсан багийн хурлыг 5 удаа зохион байгуулж, холбон зуучлах үйлчилгээнд 12 иргэнийг хамрууллаа.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хурлыг онлайнаар зохион байгуулж гэмт хэргийн хохирогч 2 хүүхэд, эрсдэлт нөхцөлд өртсөн эх, хүүхдийн асуудлыг хэлэлцэж шийдвэрүүдийг гаргалаа. Гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэргийн хохирогч, гэрч, хууль зөрчсөн хүүхдийн судалгааг авч нэгтгэхэд гэмт хэрэг үйлдсэн хүүхэд байхгүй, хохирогч 8 хүүхэд, хууль зөрчсөн 2 хүүхэд бүртгэн авч ажиллаж байна.

Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд 9 хүүхэд, 11 насанд хүрэгч нийт 20 иргэн хамрагдснаас шалтгааныг ангилж үзэхэд гэр бүлийн харилцааны зөрчил 4, стресс сэтгэл гутралаас үүдэлтэй сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай 3, насанд хүрээгүй хүүхдийн хүчирхийллийн асуудлаар 11, архины хэтрүүлэн хэрэглээтэй холбоотой 2 асуудлаар хандсан байна.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн “Ковид-19” цар тахлын үед бэлэн байдалд ажиллаж эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг эмчлүүлж байгаа 58 насанд хүрэгч, 47 хүүхдэд хийж, хүнсний багцыг 7 өрхөд, хөгжлийн болон дархлаажуулалтын

багцыг 13 хүүхдэд өгч, сэтгэлзүйн зөвлөгөөнд 52 иргэнийг хамруулж, сумдын ЗДТГ-ын нийгмийн бодлогын ажилтнуудад ковидын үед эрсдэлт гэр бүл, хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх арга зүй өгч ажиллаж байна.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан “Бид үүнийг хүсдэг” хуулийн цуврал подкаст, хүүхдийн санаа бодлыг сонсох “Хүүхдээ сонсьё” уулзалт, “Сайн жолооч”, “Хариуцлагатай аав, ээж” арга хэмжээ, “Байгаль сэтгүүлч” клубаас “Буянт голын хүүхдүүд” зуслангийн айлууд, хүн бүр “Ковидгүй зуны төлөө” нэгдэж дэглэм барьж, хүн бүр өөрсдийгөө хамгаалах хариуцлагатай байхыг уриалсан 8 удаагийн арга хэмжээ зохион байгууллаа.

Өсвөр үе залуучуудад гэр бүл, үр хүүхдийн үнэ цэнэ, аав болох хариуцлагыг ойлгуулах, цахим орчинд эерэг хандлагыг түгээх зорилгоор “Би аав боллоо” 5 цуврал контентыг цахим орчинд байршуулан 400 гаруй хүний хандалтыг аваад байна. Цар тахлын онцгой үед сургууль төгсөж байгаа Оюутнуудын сэтгэгдлийг сонсох, цахим орчинд эерэг хандлагыг түгээх зорилгоор “Сайн уу амьдрал минь” видео контентийг олон нийтийн сүлжээнд байршуулан 647 хүний хандалтыг авсан байна. Аймгийн 16 суманд залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийг байгуулж албан ёсоор YDC.mn сайтад зөвлөлийн гишүүн тус бүрийг бүртгэж үндэсний хэмжээнд баталгаажуулав.

Байгаль орчны чиглэлээр: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт зэрэг биелэлтүүдийг гаргаж холбогдох газарт хүргүүлж ажиллав. Мөн 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх арга хэмжээний саналыг БОАЖЯ-нд хүргүүллээ.

Байгаль хамгаалагчдын эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, хагас жилийн ажлыг дүгнэх зорилгоор 17 сумын байгаль хамгаалагч нартай цахим уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 21 байгаль хамгаалагч хамрагдлаа. Цахим уулзалтаар Монгол улын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 216, 217, 218 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн талаар болон төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүй, ажлын үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар ярилцлаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь төсөл”-тэй хамтран байгаль орчны салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулах газарзүйн мэдээллийн системийн анхан шатны 5 хоногийн сургалтанд бүх мэргэжилтнүүд хамрагдлаа.

Дөргөн сумын Завхан гол орчмын монгол бөхөнгийн тасархай популяц бүхий 92,0 мянган га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд хамруулахаар ХоИС, Хар ус нуур орчмын УТХГН-ийн хамгаалалтын захиргаа, Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран 2021 оны 06 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд Дөргөн суманд ажиллаж үндэслэл, солбицолыг гаргаж хүргүүлээ.

Цэцэг сумын нутаг Сутай хайрханы БНГ-т 30, Мөст, Манхан, Цэцэг, Зэрэг, Дарви сумдын нутаг Баатарын нурууны орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 70 ширхэг хилийн багана байрлуулахаар ТНС олон улсын төслийн газраас санхүүжүүлэн багана, самбар бэлэн болсон 7 дугаар сард багатаан дээрх сумдад байршуулах ажлыг сумдын тогтвортой хөгжлийн тасаг зохион байгуулахаар бэлтгэж байна.

“Бага ялгарлын шинжилгээний платформ (Icar), түүнийг хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад ашиглах нь” сэдэвт хоёр шатны цахим сургалтанд ой ургамлын олон янз байдал хариуцсан мэргэжилтэн оролцлоо. Энэхүү сургалт нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санаачилгаар ҮТХН Түншлэлийн байгууллага, (NDV-Partnership), НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр, Уур амьсгал, цэвэр агаарын холбоо (CCAC), Даян дэлхийн ногоон хөгжлийн институтын санхүүжилтээр Стокхолмын байгаль орчны хүрээлэнтэй хамтран хэрэгжиж буй “Монгол Улсын хүлэмжийн хий, агаар бохирдуулагч хийн ялгарал, тэдгээрийг бууруулах хувилбарууд дүн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх” хүрээнд зохион байгуулагдлаа.

Ховд аймгийн ойн санд хийсэн ой зохион байгуулалтын ажлыг танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа. Аймгийн ойн сангийн нийт талбайг 812.9 мян.га гэж тогтоосон байна. Аймгийн ойн санг бүрдүүлэн ургаж буй моддын зүйлийн бүрдлийн хувьд Шинэс 4806 га буюу талбайн 2.0 хувь, Хус 234 га буюу 0.1 хувь, Улиас 131 га буюу 0.05 хувь Заг 223327 га буюу 96.4 хувь Бургас 3182 га буюу талбайн 1.3 хувийг эзлэн ургаж байна.

Нөөцөд эзлэх хувиар илэрхийлбэл шинэс 546960 ш.м буюу 74.9 хувь, хус 9800 ш.м буюу 1.3 хувь, улиас 5450 ш.м 0.7 хувь, заг 94016 ш.м буюу 12.8 хувь, бургас 73650 ш.м буюу 10.1 хувийг эзлэн ургаж байна.

Тогтвортой хөгжлийн боловсрол-II төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэг чиглэл болсон "Ногоон оффис" болох суурь сургалтуудын нэг болсон ISO стандартын талаарх ойлголт, дотоод аудиторроор бэлтгэгдэх захиалгат сургалтад хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны А/81 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд ус, усан орчин ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтын байдлыг тодорхой болгох, цаашид усны зүй зохистой ашиглалт, хамгаалалтыг орон нутагт нэвтрүүлэн Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам"-ыг хэрэгжүүлэх, ус ашиглалтын хяналтыг сайжруулах ажлын хэсэг байгуулагдаж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 60 төсөвт байгууллагаас 31 байгууллагыг Шим-Ус ОНӨҮТГазартай хамтран тоолууржууллаа. Шим-Ус ОНӨҮТГазар өөрийн эх үүсвэрийн худгийг тоолууржуулж, 13 худгийг ухаалаг системд холбосон.

Орон нутгийн төсвийн 100 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, худаг хүлээж авах 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн захирамжийн дагуу Ховд аймгийн Хайрхан, Бугат, Цамбагарав багт гаргасан ухаалаг худгийн ажлыг "Алтайн Их Хар Сувд" ХХК хийж гүйцэтгэж ажлыг хүлээж аваад байна. Худгийн гүн 25-40м, 1,3л/с ундаргатай, тус бүр худгийг шалгаж үзээд улсын комисс хүлээж авах шийдвэрийг гаргаж сум орон нутгийн холбогдох удирдлагуудад хүлээлгэж өглөө.

Усны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг үндэслэн 6 дугаар сард 1 худгийн зөвшөөрөл, усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтыг үндэслэн 3 авто угаалгын дүгнэлт, барилгын материал үйлдвэрийн ус ашиглуулах дүгнэлтийг тус бүр гаргаж аймаг орон нутгийн татварын дансанд усны төлбөр 2,910,474 төгрөгийг бүрдүүллээ. Жаргалант сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 63 аж ахуй нэгжийн хаягдал усны дүгнэлтийг Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа гаргаж хяналт шалгалтын ажлыг хамтран зохион байгуулж байна.

Бүгд найрамдах Солонгос улсын Койка болон Миреко төслөөс "Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах,

менежментийн чадавхыг бэхжүүлэх” төслөөс уул уурхайн сөрөг нөлөөллийн үүсэх шалтгаан ба түүнийг хянах аргуудад суралцуулах суурь мэдлэг олгох цахим сургалтанд холбогдох албан тушаалтанууд хамрагдлаа. Тус сургалтын хүрээнд уул уурхайн сөрөг нөлөөллийн судалгаа, хөрс, усны бохирдлоос сэргийлэх, уурхайн хаягдлын боловсруулалт хөрсний суулт хотойлтын нөхөн сэргээлт, ойн доройтлыг нөхөн сэргээх, тоосжилтоос сэргийлэх сэдвийн хүрээнд 18 видео лекц хичээлийг судаллаа.

Алтны бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход оруулах хувь нэмэр /PlanetGold/ төслөөс 05 дугаар сарын 27-ны өдөр орон нутгийн төрийн албан хаагчид болон бичил уурхайчдын байгаль орчин, нийгмийн менежментийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх байгаль орчны үр дүнтэй төлөвлөлтийг бий болгох зорилгоор зохион байгуулсан “Байгаль орчин, нийгмийн менежментийн систем” сэдэвт цахим сургалтанд оролцож, аймгийн “Уул уурхайн ашиглалт нөхөн сэргээлт, бичил уурхайн өнөөгийн байдал” сэдвээр илтгэл мэдээлэл хүргэлээ.

Сургалтанд Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Ховд аймгийн Булган, Алтай сумдын төлөөлөл оролцож сумдад байгаль орчны чиглэлээр тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцлээ. Тус сургалтанд манай аймгаас 20 алба хаагч хамрагдлаа.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу “Ховд-Мөнх түшиг” ХХК-ний “Барилгын материалын үйлдвэрлэл, “Мөнх гэгээн жаргалант” ХХК-ний “Таван баялаг” мал худалдан борлуулах зах төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж нөхцөл болзолтой хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэлээ.

Мөн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу “Магнай трейд” ХХК Алтай, Булган, Жаргалант, Дарви “Эн Пи Петролиум” ХХК-ний Дарви сумын нутагт хэрэгжүүлж буй “Шатахуун түгээх станц”, “Цаг уур орчны шинжилгээний төвийн “Байгаль орчны шинжилгээний лаборатори” төслүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж баталлаа. Мөн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Хүсэл трейд” ХХК-ний Алтай, “Алтай хянган” ХХК-ний Алтай, Үенч сумын нутагт хайгуулын ажлын үеийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бүртгэлээ.

“Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж байгууллагын энгийн хог

хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд төрөөс хариуцан төлөхөөр шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/65 дугаар тушаалаар “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хянан баталгаажуулах түр журам” батлагдсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/65 дугаар тушаалыг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн А/247 дугаар захирамжаар хог хаягдлын үйлчилгээний хураамжаас чөлөөлсөн 27,549,045 сая төгрөгийг 17 сумын Засаг даргын тамгын газарт хуваарилав. Сумдад хог хаягдлын үйлчилгээний хураамжийн санхүүжилт олгосон байдал: Жаргалант сум 13,788,271, Мөст 527,197, Цэцэг 1,653,291, Мөнххайрхан 445,518, Эрдэнэбүрэн 401,581, Булган 4.942.469, Мянгад 129,943, Ховд 329,498, Чандмань 39,447, Үенч 249,444, Буянт 1.177.607, Алтай 378,923, Манхан 744,851, Зэрэг 375,326, Дарви 237,030, Дуут 29.005, Дөргөн 221,559, 1, 2, 3 сарын санхүүжилтийг эхний хагас жилийн байдлаар олгоод байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас чөлөөлсөн санхүүжилтийг сумууд Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хог хаягдлын булшлахад тус тус зарцуулна.

2021 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 88078 иргэн, 22513 өрх, 223 аж ахуйн нэгж хамрагдаж 2021 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 62,5 тн хог хаягдлыг цэвэрлээд байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо, аймгийн Засаг дарга нар хамтран захиалагч гүйцэтгэгчийн хооронд 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан №ОББҮХ/2020-22 дугаартай “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос эрх шилжүүлэх захиргааны гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн цахим хурал 2021 оны 06 дугаар сарын 17-ний өдөр болов.

Цахим хуралд аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтэн, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн нар оролцов.

ОББҮХ/2020-22 гэрээ, 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Аймгийн Засаг даргын шийдвэр, Ажлын хэсгийн хүлээн авсан акт зэргийг үндэслэн Хоггүй-цэвэрхэн-Монгол”аяны хүрээнд томоохон овооны хог цэвэрлэгээ, зуслангийн жорлонгийн асуудал шийдвэрлэх, төвлөрсөн хур хогийг багасгахад зориулан хийсэн ажлын тайлантай танилцан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны даргын 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн А/10 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн, гэрээний дагуу ажлыг 100 хувь гүйцэтгэсэн гэж дүгнэн хуралд оролцсон ажлын хэсгийн гишүүдийн 100 хувийн саналаар үлдэгдэл санхүүжилт 10,000,000.00/арван сая/ төгрөгийг олгохоор шийдвэрлэв.

Нью жуулчин турс, Дэлхийн байгаль хамгаалах сан, Ай хотел компаниудтай хамтарсан цахим уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар цахимаар хэрхэн сурталчилгаа хийх, аялал жуулчлалын байгууллагууд нь дотоод бүртгэлийг хэрхэн цахимд оруулах, хэрэглэгчдийг хэрхэн өөртөө татах талаар дэлгэрэнгүй ярилцлаа. Энэхүү уулзалтаар Ай хотел кампаний захирал, менежерүүд зөвлөгөө өглөө.

БОАЖЯ-аас “Байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангах нь” сэдэвт цахим сургалт зохион байгуулагдлаа. Сургалтаар байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийг хэрхэн идэвхжүүлэх, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг орон нутгийн төсөвт суулгах тухай чиглэл өглөө. Мөн ТНС, Дэлхийн байгаль хамгаалах сан, Эншур төслүүдээс нөхөрлөлүүдийг хэрхэн дэмжиж ажиллаж байгаа талаараа туршлагаасаа хуваалцлаа. Дархан, Хөвсгөл аймгуудын байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн холбооны үйл ажиллагааны туршлага болон Төв, Говьсүмбэр аймгуудын БОАЖГ-ын нөхөрлөлүүд туршлагаасаа хуваалцлаа.

Долоо: Сумдын мэдээлэл:

Дөргөн сум: Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжилт сонгуульд сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодод 47 төрийн албан хаагч ажиллаж, сонгуулийн ажлыг хуулийн дагуу амжилттай зохион байгууллаа. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх журмын хэрэгжилтийг хангаж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, ард иргэдийг маск, гар ариутгагчаар хангаж, мэдээлэл өгч ажиллав.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийг хангаж Цагаан хаалганд хяналтын пост ажиллуулж, сумаас орох гарах иргэдийн хөдөлгөөнд

хяналт тавин ажиллаж тайлант 6 дугаар сард 255 тээврийн хэрэгсэл, 497 иргэн сумаас орж, гарах хөдөлгөөнд оролцсон байна.

2021 оны хагас жилийн байдлаар Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтийн суманд холбогдолтой 69 ажил 77.5%, Засгийн газрын үйл ажиллагааны суманд холбогдолтой 47 ажил 71.5%-ийн биелэлттэй хэрэгжсэн хэрэгжилтийг тооцон аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүллээ.

2021 оны 06 дугаар сарын 10-11 өдрүүдэд авто тээврийн улсын үзлэг сумын төвд зохион байгуулагдаж нийт 255 машин үзлэг оношилгоонд хамрагдахаас 230 тээврийн хэрэгсэл хамрагдаж, үзлэгийн үеэр авто тээврийн хасалт 11, шилжүүлэг 29 хийгдлээ.

Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татаварт 7183751 төгрөг, агаарын бохирдлын татварт 809700 , Хувь хүний орлогын албан татварт 3562840, хог хаягдал 364500 төгрөг, байгалийн ургамал ашигласаны татварт 135500 төгрөгийг улс аймаг, сумын төсөвт төвлөрүүллээ.

Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэрийн 37 иргэнд 10.7, Ахмад настаны асаргаа 55 иргэнд 4.6, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаа 19 иргэнд 1.6, Тэжээгчээ алдсаны тэтгэмж 12 иргэнд 3.6, Өрх толгойлсон 0-18 насны хүүхэдтэй эцэг эхэд олгох тэтгэмж 4 иргэнд 1.2, Цалинтай ээж 162 эхэд 8.1, Жирэмсэн эхийн тэтгэмж 64 эхэд 2.6, Алдарт эхийн одон 2 иргэнд 400 мянга, Хүүхдийн мөнгө 1240 хүүхдэд 12.4, Хүнсний эрхийн бичиг 33 өрх 2.3 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олголоо.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд өссөн дүнгээр 6 төрлийн вакцинжуултанд 61237 мал нийт малын 92 хувийг хамрууллаа. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд угаалга 6000, туулгалт 37100, Боловсруулалт 50500 нийт 93600 толгой малыг хамруулсан нь 51 хувьтай байна. Сумын Засаг даргын 2021 оны А/45 дугаар захирамжийн хүрээнд мал эмнэлгийн тасгийн байцаагчаар ахлуулсан ажлын хэсэг Агваш багийн Гүүний ам, Сээр багийн Шандас чиглэлийн малын сэг зэм хог хаягдлыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Том малын хорогдол, төл малын бойжилтын хагас жилийн судалгаа, Хүнс, хөдөө аж ахуй газар, Азийн хөгжлийн банкнаас эрсдэлтэй айл өрхөд тараасан хүнсний хангамжийн судалгаа гаргаж хүргүүллээ.

“Ургамалын гарал үүсэл, пестицийн бүртгэл хяналтын систем”-д 6 тариаланчийн мэдээллийг оруулж сан үүсгэж ажиллав. 2021 оны 6 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, хагас жилийн тооллогоор адуу 8195, үхэр 6950, тэмээ 5612, хонь 51703, ямаа 147988 нийт 220448 мал тоологдлоо.

Орон нутгийн хөгжлийн сангийн малжуулах зээлд хамрагдаж зээл авсан малчдаас 27,4 сая төгрөгийн зээлийг татан төвлөрүүллээ.

Монгол банкны мэдээллийн санд сум хөгжүүлэх сангийн зээлтэй зээлдэгчийн мэдээллийг програмд оруулан, зээл төлсөн 7 зээлдэгчийн муу зээлийн түүхийг арилгуулж ажиллав. Орон нутгийн хөгжлийн сангийн програмд 2021 оны Орон нутгийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр арга хэмжээний мэдээг оруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай хүргэн ажиллаж, амбулатороор 37 иргэн нийт 33 удаагийн дуудлагад явж, 24 иргэнийг хэвтэн эмчлүүлж байна. Өдрийн эмчилгээнд 7 иргэн хамрагдаж оношилгоо шинжилгээнд 24 иргэн хамрагдаж эмчилгээ сувилгааг стандартын дагуу хийж гүйцэтгэв.

Зорилтот бүлгийн 30-60 насны эрт илрүүлэг шинжилгээнд 5 иргэн, Товлолын вакцинд 38 хүүхэд хамрагдсан, нэмэлтээр Covid-19 дархлаажуулалтанд 12-17 насны 344 хүүхэд хамрагдахаас 267 хүүхэд, 18-аас дээш насны 1835 иргэн хамрагдахаас 1765 иргэн хамрагдлаа. Дөргөн Эрүүл мэндийн төвийн паже хуудсаар дамжуулан цахимаар нийт 190 төрлийн мэдээлэл зөвлөмжүүдийг давхардсан тоогоор 2600 гаруй иргэнд хүргэж ажиллав.

Улсын Онцгой Комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 34 дүгээр хурлын тэмдэглэл, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Онцгой комиссын хуралдааны тогтоол, Эрүүл мэндийн газрын даргын тушаал, батлагдсан хуваарийн дагуу 2021 оны 6 дугаар сарын 21-28 өдрүүдэд Мянгад сумын хяналтын постонд сумын Эрүүл мэндийн төвийн баг үүрэг гүйцэтгэж ажилласан. Коронавирус өвчний талаарх онцын шаардлагагүй бол гадуур явахгүй байх, амны хаалтаа тогтмол хэрэглэх, ариутгал халдваргүйжилтийг тогтмол хийж, агаар салхи оруулах зэрэг зөвлөмжүүдийг өгч мэдээллийг “Дөргөн ЭМТ” цахим хуудсаар, мөн гарын авлага байдлаар ард иргэдэд тарааж, 97146549 дугаартай

эмнэлэгийн дуудлага хүлээн авах утас ажиллуулж, иргэдэд зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажиллалаа.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нар элсэлтийн ерөнхий шалгалтанд орох сурагчдын эцэг эхийн зөвшөөрснөөр тусгай хуваарийн дагуу халдвар хамгааллын дэглэм баримтлан танхимаар давтлага өгч байна.

Сургуулийн дотоод хяналтын баг гамшгийн эрсдлийн өөрийн үнэлгээг хийж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлээ.

“Суурь боловсролын чанарыг сайжруулахад мэдээлэл харилцааны технологийг оновчтой ашиглах нь” сургалтанд сургалтын менежер, холбогдох багш нар, элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлдэж байгаа сурагч болон багш нартай аймгийн Засаг дарга цахимаар уулзалт зохион байгуулж 33 сурагч, 8 багш, дундын сургалтын менежер, сургуулийн захирал нар тус тус оролцлоо.

Мянгад сум: Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 195226,3 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэвэр авагч 425 иргэнд 161321,4 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 30 иргэнд 11298,3 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрийг 71 иргэнд 22606,6 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 2 иргэнд 1327,5 мянган төгрөг тэтгэмжийн даатгалын санд 11925,0 мянган төгрөгийн санхүүжилт авч жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 8 иргэнд 11742,7 мянган төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдасны тэтгэмжийг 3 иргэнд 182,3 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг тус тус олголоо.

Сумын Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмж авдаг иргэдийг хууль журмын дагуу тэтгэвэр тэтгэмжид хамруулан мэдээллийг программд оруулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлээ. Үүнээс ахмад настан асарч буй 36 иргэн 2584000 төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмжид 34 иргэн 1840000 төгрөг, цалинтэй ээж хөтөлбөрт 208 иргэн 10400000 төгрөг, өрх толгойлсон эцэг, эх 5 иргэн 160000 төгрөг, тэтгэвэрийн 46 иргэн 52992000, шинэ төрсөн 3 хүүхэд 300000 төгрөгийн халамжийн тэтгэвэр авч байна.

Мөн ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу хийлгэж, хугацаа хэтэрсэн иргэдэд шаардах хуудас хүргүүлж ажиллалаа. Тайлант сард орон нутгийн орлогод 4049.6 мянган төгрөг оруулахаас 10573.5 мянган төгрөг оруулж орлого 261.1 хувийн биелэлттэй байна.

Гахайт, Чацаргант, Баянхошуу, Баянбулаг, Цагаанбулан багуудын малын тоо толгойн албан татварын ногдуулалт 755 өрхийн Тэмээ 1709, Адуу 11746, Үхэр 14445, Хонь 84468, Ямаа 125122 нийт 237490 толгой малд 76485.2 мянган төгрөгийн татвар ногдууллаа. Мөн Баянбулаг, Цагаанбулан багуудын татвар төлөгч иргэдтэй уулзаж нийт 440 ширхэг гарын авлага материал тараан Хувь хүний орлогын албан татвар, малын тоо толгойн албан татварын талаар сурталчлан сумын төвд болох авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн үзлэг оношилгооны зар тараав.

Коронавирус /COVID/-19-ын халдвараас урьдчилан сэргийлэх хүрээнд багуудын иргэдээс шинжилгээ авах, хяналт тавих, вакцинжуулалтанд хамруулах үйл ажиллагааны шатахууны зардалд 198000 төгрөг, ЗДТГ-ын хогны машины санхүүжилтын 70 хувь болох 23660000 төгрөг, Шим усны ОНӨААТҮГ-ын байгаль орчинд үнэлгээ хийх ажлын санхүүжилт 70 хувь болох 7000000 төгрөг нийт 30858000 төгрөгийн хөрөнгө оруулалтанд зарцуулалт хийгдлээ.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулахын тулд хугацаа хэтэрсэн 27 иргэн тус бүрд мэдэгдэх хуудас хүргэж 1 иргэнтэй эвлэрлийн гэрээ байгуулан ажиллалаа. Зээлдэгч нараас 2430000 төгрөг төлөлт хийгдлээ. Цаашид Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг судалж хугацаа хэтэрсэн зээлдэгч бүрийн гэрээтэй танилцаж эргэн төлүүлэхэд анхааран ажиллаж байна.

Төсвийн тухай хууль, НББ-ын хууль, НББ-ын олон улсын стандартыг мөрдөх, холбогдох хуулийг чандлан мөрдөж, анхан шатны баримтууд нь тамга, тэмдэгтэй эсэхийг анхаарч гүйлгээ хийх бүрдээ И-баримтыг гаргуулж ажиллалаа.

Шилэн дансны мэдээллийг хуулийн дагуу хугацаанд нь илгээж, Татварын болон Нийгмийн даатгалын шимтгэл, НББ-ийн шинэчилсэн хуулиудыг мөрдөж сар бүрийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн гүйлгээг хугацаанд нь хийж татварын байцаагч болон нийгмийн даатгалын байцаагч нарт мэдээлж байна.

Тайлант сард 5484400 төгрөгийн санхүүжилт орж ирснээс цалин, бусад зардлын тооцоо 31763175 төгрөгийн гүйлгээ хийж ажиллав.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а” дахь заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6 дахь заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/45 дугаар тушаалыг үндэслэн суманд баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх,

бүртгэлжүүлэх ажлыг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ажлын хэсэгтэй хамтран Мянгад омгийн 2000 адуунд үзлэг ангилалт хийж, чип суулгах ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд Чацаргант, Гахайт, Цагаанбулан багийн нийт 70 малчин өрх хамрагдсан ба өнгөрсөн онд адуун сүрэгтэй үзлэг ангилалт хийж, чип суулган, мал сүргийн чанар, үүлдэр угсааг сайжруулж, арчилгаа маллагааны тэргүүний технологийг нэвтрүүлэн ажиллаж өөрийн орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд зохицсон баталгаажсан үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлж байгаа 67 малчин өрхөд Цөм сүрэг бүхий малчин өрхийн “Батламж” олголоо.

Сумын хэмжээнд тохироогоор дутагдаж буй хээлтүүлэгч азарга 376, буур 27, бух 254, хуц 567, ухна 832 хээлтүүлэгч байна. Тохироо нь азарга 9, буур 16, бух 19, хуц 61, ухна 60 ба тохироогоор дутагдаж буй хээлтүүлэгч хуц 118, ухна 166 байна. Үүнээс нөхөх боломжтой хээлтүүлэгч байхгүй судалгааг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ.

Ургамлын гарал үүсэл, Пестицидийн бүртгэл хяналтын системн сургалтанд 3 удаа цахимаар оролцож сумын газар тариалан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийг бүртгэн ажиллаж байна. Сумын газар тариалан эрхэлдэг 28 тариаланчийн өрхтэй үүнээс одоогийн байдлаар 8 тариаланч өрх, 16 га талбайг тус Fine.digital.mn програмд шивлээ.

Ковид–19 цар тахлын үед тогтоосон дүрэм, журам зааврыг баримтлан хээлтүүлэгч малд ээмэгжүүлэлт, Бруцеллэз өвчний халдварыг эрт илрүүлэх тандах шинжилгээнд сорьц, дээж авах ажлыг Улсын хэмжээнд халдварт өвчнийг тандах төлөвлөгөөний 2021 оны графикийн дагуу мал эмнэлгийн тасаг, хөдөө аж ахуйн тасаг хамтран Чацаргант, Гахайт, Баянбулаг Баянхошуу, Цагийнбулан багийн нийт 1281 хээлтүүлэгч хуц, ухна малд ээмэгжүүлэлт, Бруцеллэз өвчний тандах шинжилгээний цусны дээжийг авч ажиллав.

2021 оны эхний хагас жилийн мал тооллого зохион байгууллах сумын Засаг даргын А/51 дүгээр захирамжийн дагуу ажлын хэсэг ажиллав. Сумын хэмжээнд 2021 оны эхний хагас жилийн мал тооллогоор 119 өрх хамрагдлаа.

Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран 4 иргэн аж ахуйн нэгжид Э дугаар олгож, гэрээ байгуулан гэрчилгээжүүлж, 5 иргэнд газар өмчлөх гэрчилгээ олгох 15 иргэн аж ахуйн нэгжид кадастрын зургаар үйлчилгээ

үзүүлж нийт 19 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. Газрын гэрээ гэрчилгээний лавлагааг 7 иргэнд олгож, цахимаар мэдээлэл өглөө.

Монгол хадран загасны шилжилт хөдөлгөөн тус сумын Чацаргант багийн нутаг дэвсгэр Ховд голын хавцлын ам нэртэй газарт шилжсэнтэй холбогдуулан Баянбулаг, Чацарганат баг хариуцсан Байгаль хамгаалагч загасны үржлийн үеийн шилжилт хөдөлгөөний үе буюу 2021 оны 05 дугаар сард Шижигтийн хавцалд хийх хяналт шалгалтыг эрчимжүүлж цаашид хяналт шалгалтыг тогтмолжуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Иргэнээс ирүүлсэн мэдээллийн дагуу сумын Байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар томилогдон ажиллаж, Цагаанбулан багийн нутаг дэвсгэр “Арлын ам нэртэй” газарт 3 ширхэг монгол хадран загас зүй бусаар хорогдсон байсныг зохих газруудад мэдэгдэж мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, зөвлөмжийн дагуу устгалд оруулан, зургаар баримтжууллаа.

“Цэвэр орчин-Эрүүл амьдрал тохижилт” бүтээн байгуулалт, тохижилт үйлчилгээний аяныг 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 45 хоногийн хугацаанд болзолт уралдаан зарлаж аяны хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Хаврын ээлжит бүх нийтийн цэвэрлэгээний ажлаар сумын нэгдсэн хогийн цэгээс Сар хайрханы чиглэлийн хатуу хучилттай зам дагууд Улаан харын үзүүр хүртэлх 23 га талбай, Хадан хясаанаас Ховд голын сав дагууд Хөх чулуу хүртэлх 8 га талбай, нийт 31 га талбайд, 1 ААНБ, 3 албан байгууллагын эзэмшил газрын 50 метрийн тойрогт чулуу түүх цэвэрлэгээний ажлыг зохион байгуулснаар 7 албан байгууллагын 126 ажилтан албан хаагч, 4 аж ахуйн нэгж байгууллагын 12 ажилтан, нийт 138 албан тушаалтан хамрагдлаа.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчид Ковид-19 цар тахал өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан цахим хичээлийг БШУЯ-аас гаргасан хуваарийн дагуу сургалтын үйл ажиллагааг цахимаар явуулж энэ хичээлийн жилийн анги дэвших, сургууль төгсөх ажлыг хуваарийн дагуу хийсэн. Төгсөх 12 дугаар ангийн сурагчдыг БСШУЯ-аас гаргасан журмын дагуу хуваарь гарган халдвар хамгааллын дэглэм баримтлан танхимаар давтлагыг мэргэжлийн хичээлийн багш нар хуваарийн дагуу чанартай өгч, анги удирдсан багш нар цахимаар

сурагчидтайгаа ажиллаж дархлаа дэмжсэн амин дэмтэй хоол хүнс хэрэглэх, халдвар хамгааллын дэглэмээ баримтлан аль болох гэрээсээ гарахгүй байхыг зөвлөлөө.

Сургууль, дотуур байранд халдвар хамгааллын дэглэм баримтлан ариутгал халдваргүйжилтийг өдөр бүр хуваарийн дагуу хийж өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган багш ажилчид хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Анги удирдсан багш нар болон нийт мэргэжлийн хичээлийн багш нар Google meet, Zoom ашиглан цахимаар хичээл зааж сурагчидтайгаа холбогдож хичээл, сургалтын ажлыг зохион байгуулж хичээлийн дүн гаргах тайлан мэдээг цаг хугацаанд гүйцэтгэж байна.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас явуулж буй онлайн сургалтанд захирал, сургалтын менежерүүд, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрны багш нар холбогдох ажилтнуудын хамт оролцлоо.

Сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны тайлант 06 дугаар сард нийт 105 иргэнд амбулаторийн үзлэг хийж, яаралтай тусламжийн 18 удаагийн дуудлаганд явж, 38 иргэнийг хэвтүүлэн эмчилж, өдрийн эмчилгээнд 12 иргэн, уламжлалт эмчилгээнд 14 иргэн, гэрийн тусламж үйлчилгээнд 15 иргэн, оношлогоо шинжилгээ 45 иргэнийг хамрууллаа. Мөн 0-3 сартай 4 жирэмсэн эхийг жирэмсний эрт хяналтанд авч, 70 эхийг хөх үзлэгийн шинжилгээнд, умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт 15, хамрагдвал зохих нийт 8 эмэгтэйчүүдийг 100 хувь шинжилгээнд хамруулж ажиллалаа.

Товлолын дархлаажуулалтын вакцины 1 дүгээр тунд 1656, 2 дугаар тунд 1428, Pfizer вакциныг 60 хүүхдэд, 17 том хүнд хийж үйлчиллээ.

Үйлчлүүлэгч болон олон нийтэд чиглэсэн /амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих, шүлс, нус цэрээ ил задгай хаяхгүй байх, бохир гараа ам хамар нүдэндээ хүргэхгүй, нухахгүй байх, өрх гэрийн гишүүн хоорондоо аяга, таваг халбагаа солихгүй байх, гэр бүлийн гишүүн тус тусдаа гар нүүрийн алчууртай байх, гарын эрүүл ахуй сахин, гар угаах, гар утсыг ариутгалын бодисоор цэвэрлэж хэвших, гар утсаар бага насны хүүхдийг тоглуулахгүй байх, орчны цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт, амны хаалт тогтмол зөв зүүж хэвших гэх мэт мэдээ мэдээллийг олон нийтэд цахим хэлбэрээр тогтмол хүргэж байна. Эрүүл мэндийн хөтөч ажиллуулан үйлчлүүлэгчдийн халууныг үзэж тэмдэглэл хөтөлж ажиллав.

Мөн хяналтын постонд хариуцлагатай жижүүр томилон постоор орж гарч байгаа иргэдийг бүртгэлжүүлж халууныг үзэж тэмдэглэн ажиллаж байна. Улаанбаатар хотоос ирсэн 10 хүнд PCR-ийн шинжилгээ авч, 38 хүнд түргэвчилсэн оношлуураар ковид-19 шинжилгээ авч үйлчиллээ. **н ажлын чиглэлээр:**

Эрдэнэбүрэн сум: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороонд 7 иргэн, 5 санал авах байранд 37 албан тушаалтан ажиллалаа. Сумын сонгуулийн хорооны гишүүний 6 буюу 85.7 хувь нь эмэгтэй, хэсгийн хорооны гишүүний 28 буюу 75.6 хувь нь эмэгтэй байв.

АТБӨЯТХ-ийн үзлэгт нийт 260 авто машин хамрагдаж агаарын бохирдлын төлбөрт 1245.7 мянган төгрөг, автын татварт 9672.4 мянган төгрөгийг тус тус улс, аймгийн төвлөрсөн төсөвт тушаалаа. Мөн ашиглах боломжгүй болсон 20 тээврийн хэрэгсэл улсын бүртгэлээс хасалт хийлгэж 34 машин шилжүүлэг хийгдэж үзлэгийг амжилттай явууллаа.

Эрдэнэбүрэн сумын зээ хүү, Хонгио багийн харьяат Содномын Үрэлийн ууган хүү Чандмань сумын харьяат Санжмаагийн Цэрэнжамцын хандиваар ирсэн 380 вт агаарын шугам, цахилгааны шийд, тоолуур зэргийг суурилууллаа.

Хүүхдийн цэцэрлэгийн анги, гал тогоо, гадна орчин мөн сумын төв гудамж, хогийн цэгийг бүрэн камержууллаа. В,С вирусын эрт илрүүлэгийн 468 хүнд хийж оношлов.

Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний дагуу хорио цээрийн дэглэмийг чанд баримтлан сурагч багш бүрийн халуун хэмжих, гар ариутгах, тусгайлан бэлтгэсэн анги танхимд, сурагч багш бүр маскаа зүүж давтлага үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна.

БШУЯ-аас зохион байгуулж буй сургуулийн өмнөх боловсрол, боловсролын байгууллагуудын 2022 оны төсвийн төслийг цахимаар хүлээн авч “Цахим төсвийн төсөл–2022” сургалт нь зохион байгуулагдлаа. Жайка Олон улсын байгууллагын санхүүжилтээр 2018-2022 онуудад хэрэгжиж буй “Суурь боловсролын чанарыг сайжруулахад МХТ-ыг оновчтой ашиглах нь” төсөл амжилттай хэрэгжиж Ховд аймгийн ЕБС-ийн багш нар цахим хэрэглэгдэхүүн, видео хичээл бэлтгэж сургалтанд ашиглаж байна. Уг төслийн хүрээнд баруун бүсийн хэмжээнд дээрх цахим хэрэглэгдэхүүн, видео хичээлийг туршин хэлэлцэх онлайн сургалт 2021 оны 6 дугаар сарын 14-19-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Мөнххайрхан сум: Сумын Засаг даргын Тамгын газрын хурал 1 удаа, сумын Онцгой комиссын хурал 4 удаа хуралдаж, цаг үеийн ажлын талаар хэлэлцэн, 6 дугаар сард хийх ажлын талаар үүрэг чиглэл энэ чиглэлээр бүх нийтээр дагаж мөрдөх сумын Засаг даргын 5 захирамж гаргаж холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

2021 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотоос ирсэн иргэнд “Ковид-19” халдварын тохиолдол батлагдаж, 18-ны өдөр ойрын хавьтал 2 иргэнд халдварын тохиолдол батлагдаж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон шийдвэр гаргалаа.

Монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн суманд холбогдох заалтуудын хэрэгжилтийг хагас жилийн нэгтгэн тооцож холбогдох газарт хүргүүллээ.

Сумын Санхүүгийн алба нь Төсөвт байгууллагуудын 6 дугаар сарын санхүүжилтийн эрхийг нээх, гүйлгээг хянан баталгаажуулах, орон нутгийн төсвийн орлогод 6 дугаар сард орсон орлогыг орон нутгийн ерөнхий орлогын дансанд хааж төсөвт байгууллагуудын 6 дугаар сарын өглөг, авлагын мэдээг хүлээн авч Сангийн яамны удирдлагын мэдээллийн системд шивлээ.

Шилэн дансны вэйб сайтад төсвийн төвлөрүлэн захирагчийн сар бүр оруулах 5, тухай бүр оруулах 6 мэдээллийг шивж байршууллаа.

Санхүүгийн дэмжлэгт 6 дугаар сарын хуваарийн дагуу 38626300 төгрөг ирснийг төсөвт байгууллагуудад дараахь байдлаар хувиарлан олголоо. Үүнд: ИТХуралд 5955000 төгрөг, ЗДТГазарт 28722297 төгрөг, Соёлын төвд 10655400 төгрөг, ерөнхий боловсролын сургуульд 538400 төгрөг, Хүүхдийн цэцэрлэгт 197000 төгрөг, Эрүүл мэндийн төвд 509000 төгрөг тус тус олголоо.

Орон нутгийн 9 нэр төрлийн орлогыг шилэн дансны вэйб сайтад шууд татан оруулахаар excel программаар файл бэлтгэж шилэн дансанд байршууллаа. Сар бүр орлогын нэр төрлийн мэдээг гаргаж албажуулан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэнд цаасаар болон цахимаар хүргүүллээ.

Тайлант сард 6-н байгууллагын 107 зардлын ваучер импортлож өгөгдлийг дамжуулан, нийт мөнгөн дүнгээр 185.081,8 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримт болон бусад баримтыг үндэслэн шивлээ.

Тайлант 6 дугаар сард ИТХ-ын санхүүжилтэнд 5955000 төгрөгийн санхүүжилт авч 7 төлбөрийн хүсэлтээр 4508666 төгрөгийн гүйлгээ, ЗДТГ-ын санхүүжилтэнд 28722297 төгрөгийн санхүүжилт авч 15 төлбөрийн хүсэлтээр 23620561 төгрөгийн гүйлгээ бэлтгэж төрийн санд хүлээлгэн өгч шивүүллээ. Соёлын төвийн сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн мэдээг гаргаж сумын нэгтгэлд орууллаа.

Соёлын төвийн санхүүжилтэнд сарын хуваарийн дагуу 10655.0 мянган төгрөг авч 11 төлбөрийн хүсэлтээр 6784.1 мянган төгрөгийн гүйлгээ хийлээ. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх ажлын саналыг сумын иргэдээс цахим системээр 80 гаруй, саналын хуудсаар 22 санал авсан. Шилэн дансны вэйб сайтад Соёлын төвийн тухай бүр оруулах 8 мэдээлэл, сар бүр оруулах 3 мэдээлэл бүгд 11 мэдээллийг шивж байршууллаа.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөр 31077648 төгрөг, зээлийн хүү 1217496 төгрөг, зээлийн хугацаа хэтэрсний алданги 894583 төгрөгийн орлого төвлөрүүллээ. Эдгээр орлогыг дансны хуулгаас түүвэрлэн холбогдох иргэдийн зээлийн үлдэгдэл, алдангийн үлдэгдлээс хасалт хийж бүртгэл хөтөллөө. Сум хөгжүүлэх сангийн программ Монгол банкны мэдээллийн системд холбогдсонтой холбоотой иргэдийн зээл төлөлт сүүлийн саруудад өсөн нэмэгдэж байна.

Тайлант сард орон нутгийн төсөвт 3078,9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 8739.1 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 283,8 хувиар биелүүлэв. Өссөн дүнгээр 18329,4 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 20147,1 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 109,9 хувьтай байна.

Сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/101 дүгээр захирамжаар өвөлжөө, хаваржаа, намаржааны бүс нутгийг малын хөлөөс чөлөөлсөн шийдвэрийг хэрэгжүүлж Алаг, Сэнхэр, Борт багийн нутаг дэвсгэрт зөрчил гаргасан айл өрхүүдэд холбогдох мэргэжилтэн, албан тушаалтны хамт мэдэгдэх хуудас хүргүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 1/895 тоот албан бичгийг хүлээн авч суманд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгохоор баталсан талбайд өөрчлөлт оруулах асуудалд санал хүргүүлж, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “Дэмжихгүй” саналыг тогтоолоор гаргаж хүргүүлэв.

Сумын Газрын даамал газар эзэмших 3 өргөдөл, газар өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх 1 өргөдөл, газар эзэмших эрхийн гэрчилгээ барьцаалах 2 хүсэлт хүлээн авч шийдвэрлэлээ. Иргэдэд газар эзэмших эрхийн 6ш гэрчилгээ бичиж гэрээ байгуулсан.

Тайлант сард нас баралтын бүртгэл 3, төрсний бүртгэл 3, баг хоорондын шилжилт хөдөлгөөний бүртгэл 1, цахим үнэмлэх олголтын бүртгэл 16, цахим үнэмлэх дахин олголтын бүртгэл 2, цахим үнэмлэх захиалсан 6 иргэн, үүнээс шинээр 16 нас хүрч цахим үнэмлэх захиалсан 1, насны сунгалт 5 иргэн хийлгэж, нийт 6 иргэнд лавлагаа олгож, 37 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлэв. Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Иргэний улсын бүртгэлийн онлайн, оффлайн систем”-ийн талаарх нэгдсэн онлайн сургалтанд хамрагдаж мэдээлэл авлаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 3 иргэний 2,3 сая төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 2 иргэний 1,1 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэний 1,0 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдлээ.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар иргэдээс ирсэн төслүүдийг хэлэлцэж ахмад настны аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох төсөлд Хаг багийн иргэн Э.Долгорсүрэнгийн "Арьс нэхийгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх оёдлын төсөл"-д 2,0 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Сэнхэр багийн иргэн Б.Туяагийн "Нэхий боловсруулах, бага оврын үйлдвэрлэл" төсөлд 3,0 сая төгрөг, Иргэн, аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд 35-аас дээш насны хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэдийн төслөөс С.Гансүхийн "Хүлэмж" төсөлд 3,0 сая төгрөг тус тус олгохоор шийдвэрлэж, хөтөлбөрийн хүрээнд зээлдэгч нартай гэрээ байгуулан санхүүжилтийг олгоод байна.

Нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр 29 иргэн, тэтгэмж 56 иргэн, жирэмсэн эхийн тэтгэмж 30 иргэн, хүүхэд асаргааны тэтгэмж 105 иргэн, утасны хөнгөлөлт 2 иргэний мэдээллийг програмтай тулган санхүүжилтийг иргэдийн харилцах дансанд олгууллаа. Хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ авдаг 21 өрхийн 128 иргэнд 1680.000 төгрөгийн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг "Их хунт" аж ахуй нэгжээр олгов.

Короно вируст халдвар цар тахлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх түр журмыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган журмын дагуу тусгаарлан ажиглах байранд байрласан эрсдэл өндөртэй 6 хүүхдэд эрсдлийн үнэлгээ хийлээ.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн гэрээний хугацаа дууссан, графикт хугацаа хэтэрсэн зээлдэгч нараас 21 зээлдэгчийн эргэн төлөлтийг төлүүлэв. Үндсэн зээл 59.100.212 төгрөг, хүү 2.203.249 төгрөг, алданги 1.194.583 төгрөг нийт 62.498.044 төгрөгийн эргэн төлөлтийг сум хөгжүүлэх сангийн 100161155401 дансанд төвлөрүүлэв. Сум хөгжүүлэх сангийн зээлийн программд 59 зээлдэгчийн мэдээллийг дахин шинэчлэн шивж орууллаа.

Короновируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын тархалтай холбогдуулан халдвар хамгаалалын дэглэмийг баримтлах, иргэдэд тогтмол бээлий масктай үйлчлэх спиртэн суурьтай гар ариутгагчийг тогтмол хэрэглэхийг дэлгүүрүүдэд зөвлөлөө.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас малчдад хүргэх тусламжийн 100 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг татан авч малчдад олголоо. Хүнснийн гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийн болон үнэнийн судалгаа, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг 7 хоног бүр аймгийн ХХААГ-т хугацаанд нь хүргүүлж байна.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нар ЭЕШ-ийн давтлага өгч сорилго шалгалтыг хичээл тус бүрээр 1, тайлант сард нийт 8 удаагийн сорилгод сурагчдыг бүрэн хамруулж анализ дүгнэлтийн дагуу ажиллаж, элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэгчдэд зориулсан зөвлөх багш багш нар өдөр бүр сургалт зохион байгуулж, 12 дугаар ангийн сурагчид бүрэн хамрагдаж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР